



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/405

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 11 дүгээр цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилт /Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгч "БГМ" ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Батбаяр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн гэрээт ажилтан

Б.Сонинтуяа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн


Ц.Тулга - 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

Нарийн бичгийн

дарга: С.Өнөржаргал - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн

2. 11 дүгээр цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилт /Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгч "БГМ" ХХК-ний ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Батбаяр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Т.ЖАРГАЛСАЙХАН



02.01779
D/Zax-A/452-Bo